



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 1/38

Хархорин сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дэх заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.3 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Тус сумын 2, 3, 5, 7 дугаар багт байрлах 23 нэгж талбарын 28322м² газрыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу хавсралтад зааснаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч Э.Цогбаатар, Н.Батцэцэг, Ж.Батмөнх, Б.Баасансүрэн, М.Сэрээтэр, П.Баярсайхан, М.Цогзолмаа, М.Цэвэлмаа, ЛМДШ ХХК, Г.Оюунаа, Д.Оюунчимэг, Б.Алтанпүрэв, Б.Мөрөн нарт газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (А.Норпил), (Ч.Баттулга) нарт даалгасугай.

3.Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2006 оны 41 дугаар захирамж, 2024 оны А/197 дугаар захирамжийн О.Батбаяртай холбогдох хэсэг, 2019 оны А/231 дугаар захирамж, 2014 оны А/207 дугаар захирамжийн МЭШ ХХК-тай холбогдох хэсэг, 2024 оны А161 дугаар захирамжийн М.Цогзолмаатай холбогдох хэсэг, 2023 оны А/280 дугаар захирамжийн Д.Баянжаргалтай холбогдох хэсэг, газар эзэмших эрхийн 0078266, 0000327580, 0000327581, 0000327577, 0000246953, 0000263971, 000044798, 0000327972 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ



401100375